

## АМЕРИКИЙН ФЕРМЕРИЙН АЖ АХУЙ

Ц. Баатар

Фермерийн аж ахуй бол АНУ-д хөдөө аж ахуйг эрхлэн хөтлөх сонгомол хэлбэр юм. АНУ-ын хөдөө аж ахуйн хөгжлийн өнөөгийн нүүр царайг тодорхойлж буй энэхүү фермерийн хэмээх хувийн аж ахуйн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны тухай төвч өгүүлье.

Газрын ашиг шим, өөрийн биенийн болон оюуны хүч хөдөлмөрт түшиглэн нарийн төрөлжсөн, өндөр механикжсан үйлдвэрлэл эрхэлдэг хувийн аж ахуйтныг фермер гэнэ. Фермер бүрэн бие дааж ажилладаг, янз бүрийн удирдлагын шат дамжлагагүй зөвхөн эзэн л өөрөө бүхнийг шийдэж үйлдвэрлэлээ эрхэлж явуулна. Фермерүүдийн эрхэлж байгаа аж ахуйн хэлбэр хэмжээ, бүтэц, зохион байгуулалт зэргийг үндэслэн өрхийн Фермерийн аж ахуй, хамтарсан фермерийн аж ахуй, хөдөө аж ахуйн корпораци буюу компани гэж хувааж үздэг. Эдгээр фермерийн аж ахуйнуудыг тус бүрээр нь арай дэлгэрэнгүй авч үзье.

**Өрхийн фермерийн аж ахуй.** Өрхийн фермерийн аж ахуйг дотор нь үйлдвэрлэлийн үндсэн хэрэгслийг эзэмшиж байгаа онцлогоос хамаарч, өмчлөгч, хагас өмчлөгч, түрээслэгч фермер гэж ялгадаг.

Өнгөрсөн зууны сүүлч, энэ зууны эхэнд фермер газар, мал болон үйлдвэрлэлийн үндсэн хэрэгслийн бүрэн эзэн байсан уламжлалтай. Тэд шаардлагатай үед эзэмшил газрынхаа зохих хэсгийг түрээслэдэг байжээ. Өрхийн фермерийн аж ахуйн бүх ажлын голыг эзэн өөрөө гэр бүлийн гишүүдийнхээ хүчээр нугалж, хүндрэлтэй үед улирлын ажилчин хөлсөлж авдаг байсан байна. Фермерийн аж ахуйг эрхлэн хөтлөх, үйлдвэрлэлээ төлөвлөх, материал, техник хэрэгсэл олох бүтээгдэхүүнээ борлуулах зэрэг бүх асуудлыг эзэн бие дааж шийдвэр гаргаж түүнийг өөрөө хэрэгжүүлж байв. Эзэн фермерийн аж ахуй тээрээ тогтвор суурьшилтай амьдарна. Өрхийн фермерийн аж ахуйн үндсэн дүр төрх сүүлийн үе хүртэл ийм байжээ.

Шинжлэх ухаан техникийн дэвшлийн ачаар хөдөө аж ахуйн салбарт өндөр бүтээмжтэй техник, технологи бий болжээ. Үүнийг дагалдан үйлдвэрлэлийн зардал урьд өмнө үзэглээгүйгээр ихэсч фермерүүдийн өрсөлдөөнт тэмцэл ширүүссэн байна. Энэ нөхцөл байдалтай уялдан фермерүүд аж ахуйгаа томсгохыг эрмэлздэг болжээ. Томсгосон өрхийн фермерийн аж ахуйд нэлээд өөрчлөлт гарав. Тэд зохих хэмжээгээр хөлсний ажиллах хүч хэрэглэх болсон байна. Фермерийн эздийн зарим нь аж ахуй дээрээ амьдрахаа больж, фермерийг эрхлэн хөтлөх ажлыг хөлсний менежерээр хийлгэх болжээ.

Америкийн эдийн засагч Д. Паарлберг «Эзэн, түүний гэр бүл ажиллах хүчний ихэнх хэсгийг хангаж байгаа тийм аж ахуйг өрхийн фермерийн аж ахуйд тооцох нь зүйтэй<sup>1</sup> гэжээ.

Үнэхээр тоогоороо ч тэр, бүтээгдэхүүн борлуулалтын хэмжээгээр ч тэр хөлсний хөдөлмөрийн өчүүхэн хувийн жин бүхий өрхийн фермерийн аж ахуй тэнд зонхилж байна. Үйлдвэрлэлийн хэр хэмжээнээс хамаарч өрхийн фермерийн аж ахуйг дотор нь гурав хуваадаг. Бүтээгдэхүүн борлуулалтын хэмжээ нь жилд дундчаар 40 мян. доллар

Ц. Баатар —Зүүн хойт Ази судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан,

хүртэлхийг жижиг, 40—100 мян. доллар хүртлэхийг дунд, 100 мян. доллараас дээш байвал их өрхийн фермерийн аж ахуй гэж үздэг байна.

АНУ-ын нийт фермерийн (гэр бүлийн, хамтарсан, корпораци) аж ахуйн 72 хувийг жижиг фермерийн аж ахуй эзэлнэ. Эдлэн газрын 29 хувь, машин тоног төхөөрөмжийн 31 хувь, ажиллах хүчний 44 хувь нь энд байх бөгөөд таваарын бүтээгдэхүүний ихэнх хувийг үйлдвэрлэнэ.<sup>2</sup>

Дунд фермерийн аж ахуйнууд хамгийн тогтвор суурьшил муутай аж ахуй байдаг аж. Тэдний зарим хэсэг нь үйлдвэрлэлээ өргөтгөн том фермерийн аж ахуй болдог байна. Ихэнх нь ширүүн өрсөлдөөнийг давалгүй үйлдвэрлэлээ цомхотгож жижиг фермерийн аж ахуйн хэлбэрт шилжин орж ажилладаг юм байна. 1978 онд дунд фермерийн аж ахуйн нийт тоо 363,4 мянга буюу нийт фермерийн аж ахуйн 14 хувийг эзэлж байсан бол 1986 он гэхэд 294,5 мянга буюу 13,3 хувь болж буурчээ.<sup>3</sup>

Их өрхийн фермерийн аж ахуйн үйлдвэрлэл нь нарийн төрөлжсөн, өндөр механикжсан, үр ашиг ихтэй. Энд зөвхөн сүүний чиглэлийн өрхийн фермерийн аж ахуйгаар жишээ авахад саалийн 100 үнээтэй фермд 1,5 хүн, 500 үнээтэй фермд 7—10 хүн, 3200 үнээтэй фермд 47 хүн ажиллаж байна.<sup>4</sup>

АНУ 1960 онд нийтдээ 17,5 сая үнээтэй, нэг үнээнээс 3500 литр сүү сааж байсан бол 1986 оноос 10,8 сая болж нэг үнээнээс 6,6 мянган литр сүү саах болжээ. Ийм замаар үнээний тоог цөөрүүлж, нэг үнээнээс саах сүүний гарцыг байнга нэмэгдүүлж байна.

Мах, сүүний болон ер нь аль ч салбарт биотехнологийн шинжлэх ухаан хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаа болсны нэгээхэн жишээ нь энэ юм.

Америкийн эрдэмтэд тахианы мах, өндөг, малын тэжээл, ногоо, шүүст жимснээс бусад хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өрхийн фермүүд дээр явагдах нь илүү үр ашиг өгдөг гэж үзэж байна.

1991 оны эхээр АНУ-д 1.02 сая жижиг, 806200 дунд, 317700 том фермерийн аж ахуй байлаа.<sup>5</sup>

**Хамтарсан фермерийн аж ахуй.** АНУ-д хамтарсан фермерийн аж ахуйг тэгэж ингэж байгуулна гэсэн заавар, дүрэм, хууль тогтоомж байхгүй. Хамтарсан ферм бие даасан хуулийн этгээд болохын хувьд эзэмшигчид нь аж ахуй-санхүүгийн талаар материаллаг хариуцлага хүлээдгээрээ корпорациас ялгаатай. Мах, сүү үйлдвэрлэх, малын тэжээл бэлтгэх зэрэг ажилд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт зайлшгүй шаарддаг. Энэ үед фермерүүд үйлдвэрлэлийн үндсэн фонд болох газар, мал, машин, тоног төхөөрөмж, ажиллах хүчээ нэгтгэж хамтарч хөрөнгө гаргаж урьдаа тавьсан зорилтоо хэрэгжүүлдэг байна. Чухам ийм замаар хамтарсан фермерийн аж ахуйнууд үүсч бий болдог байна. Ихэнх тохиолдолд хоршин ажиллагсад нь ойрын хамаатан салангүүд байдаг аж. Зарим үед хөдөө аж ахуйтай холбоогүй хөрөнгө мөнгөтэй хүнтэй хамтарч үйлдвэрлэлээ өргөтгөдөг байна. 1982 оны байдлаар АНУ-д 223 мянган хамтарсан фермерийн аж ахуй байв. Энэ нь нийт фермерийн аж ахуйн 10 хувьтай тэнцэнэ. Хамтарсан фермерийн аж ахуйн жилийн бүтээгдэхүүний борлуулалт 21.5 тэрбум доллар буюу хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний борлуулалтын 16.3 хувийг эзэлж байна.<sup>6</sup>

**Корпораци.** Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн шинэ хэлбэр болох корпораци АНУ-д ихээхэн өргөжиж байна. Газар эзэмшлийн байдлаас хамааран эзний бүрэн эзэмшилд буй, газрыг хагаслан өмчилсөн, тү-

рээсний корпораци гэж хуваадаг. Газрыг бүрэн эзэмшиж буй 28,6 мянган корпораци байгаа бөгөөд хөдөө аж ахуй дахь корпорацийн 47,8 хувийг эзэлнэ. Газрыг хагаслан өмчилсөн 23 мянган корпораци бүх корпорацийн 38,5 хувийг, түрээслэгч корпораци 8,2 мянган буюу 13,7 хувийг тус тус эзэлж байна.<sup>7</sup>

1982 онд нэг корпорацид дундчаар 1521 мянган долларын үнэ бүхий газар, барилга, 144 мянган долларын үнэ бүхий машин тоног төхөөрөмж, 4,2 трактор, 1,3 үр тарианы комбайн оногдож байлаа. Корпорацийг дотор нь өрхийн, өрхийн биш гэж хоёр хуваадаг. Өрхийн корпорациуд төвлөрсөн хөрөнгө оруулалт ихээр шаардах хөвөн, чихрийн манжин тариалах малын тэжээл, тахианы мах, өндөг үйлдвэрлэх зэрэг үр өгөөж ихтэй салбарт хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалт хийж үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд эрх зүй-зохион байгуулалтын хувьд фермерийн аж ахуйг бодвол нэлээд давуу талтай. Корпорацийн эзэд аз туршсан шийдвэр гаргах боломжтой байдаг боловч амжилтгүй болсон үед тэд өрхийн фермерийн аж ахуйгаас ялгаатай нь түүний төлөө хувийн хөрөнгөөр биш харин хувь нийлүүлсэн хөрөнгөөр хариуцлага хүлээнэ.

Хөдөө аж ахуйн блтээгдэхүүнийг дахин боловсруулж борлуулалт хийдэг хэд хэдэн хувь нийлүүлсэн аж ахуйнууд хамтарч үйлдвэрлэл явуулах болсноор өрхийн биш корпораци үүсчээ. 1982 оны байдлаар тэд нийт газрын 1,5 хувь буюу 5,8 сая га газар эзэмшиж, 8,6 тэрбум долларын бүтээгдэхүүн борлуулсан нь АНУ-ын хөдөө аж ахуйн таварын бүтээгдэхүүний үнийн 6,5 хувь болж байлаа. Судалгаанаас үзэхэд өрхийн биш нэг корпорацид 4,6 байнгын, 67 улирлын ажилчин, албан хаагчид, дундчаар 10-аад ачааны машин, 7 трактор оногдож байлаа.

Фермерийн аж ахуйн хэлбэр, зохион байгуулалтын ерөнхий дүр төрхийг товчхон өгүүлэхэд ийм байна.

Америкийн фермерүүдийн холбооны ерөнхийлөгч Р. Далена 80-аад оны эхээр хийсэн судалгаандаа ХХI зуунд АНУ-ын фермерийн аж ахуйн 90 хувийг өрхийн фермерийн аж ахуй эзэлсэн хэвээр байх болно гэсэн таамаглал дэвшүүлж байв.<sup>8</sup> Тэгвэл 90-ээд оны байдал, цаашдын төлөв ямар байгаа талаар авч үзье. Одоо АНУ-д 2,14 сая том, жижиг фермерийн аж ахуй байгаа нь арван жилийн өмнөхөөс 11 хувиар цөөрсөн байна. 1995 он гэхэд тэдгээрийн тоо 3,5 хувиар 2000 он гэхэд 6 хувиар цөөрнө. Өөрөөр хэлбэл ХХ зууны эцэст Америкт 2,01 сая фермерийн аж ахуй байх болно гэж тус орны Хөдөө аж ахуйн Яамны эдийн засгийн судалгааны мэргэжилтэн Томас Кармин, Донн Раймонд нар үзэж байна.<sup>9</sup> Тэдний үзэж байгаагаар 50, 60-аад онд хөдөө аж ахуйд механикжуулалт, эрлийз үр тариа, шим бордоо өргөн нэвтэрсэн явдал тэр үеийн фермерийн аж ахуй цөөрсөн үндсэн шалтгаан болсон бөгөөд 90-ээд онд фермерийн аж ахуйн тоо цөөрсөн нь зээлийн хүү, экспортын худалдаа зэрэг гадаад эдийн засгийн хүчин зүйлүүдээс хамаарч байгаа аж.

Томоохон фермүүд хөдөө аж ахуйн эдэлбэр газрын тэн хагасыг эзэлж, асар их бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. 1987 онд 75700 томоохон фермд хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний зах зээлийн өртгийн тэн хагас нь оногдож байв. Хоёр зууны заагт томоохон фермерийн аж ахуйн тоо нэмэгдэж, үйлдвэрлэлийнх нь бөөгнөрөл ч өсөх ажээ. Үүний зэрэгцээ хөдөө аж ахуйн орлогын өөрчлөлтөөс нэг их хамаарахгүй олон жижиг фермерийн аж ахуй үлдэнэ гэж дээрх хоёр мэргэжилтэн дүгнэжээ.

Америкийн хөдөө аж ахуйн хөгжилд сургалт, шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн нэгдсэн систем чухал байр суурь эзэлнэ. Шинжлэх ухааны үйлдвэрлэлтэй уялдуулах талаар улсаас онцгой анхаарал тавьдаг. Америкийн хөдөө аж ахуйн шинжлэх ухааны байгууллага нь энэ чиглэлийн их сургуулиуд дээр төвлөрдөг байна. Тэдний жилийн төсөв нь олон зуун сая долларт хүрч байна. Төсвийн ихээхэн хэсгийг судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд зориулдаг. Их сургуулиуд фермерийн эздийн боловсролыг дээшлүүлэхэд ихээхэн анхаарч тэдэнтэй байнга хамтран ажилладаг байна. Судалгааны үр дүнд бий болсон шинэ техник, технологийг фермерийн аж ахуйд нэвтрүүлэхэд гарах бүх зардлыг эрдэм шинжилгээний байгууллага гаргана. Үүнд сургалт ч хамаарна. Шинжлэх ухаан, сургалт, үйлдвэрлэлийг ийнхүү нягт уялдуулснаар шинжлэх ухааныг үйлдвэрлэх хүчин болгох орчлыг ихээхэн богинсгодог байна. Фермерийн эзэд ч орлогынхоо тодорхой хэсгийг судалгааны байгууллага, хамт олныг санхүүжүүлэх сонирхолтой байдаг ажээ. Зарим фермерүүд өөрийн гэсэн цомхон судалгааны төв ажиллуулж байна. Фермерүүд ийнхүү аж ахуйгаа шинжлэх ухааны үндэслэлтэй эрхлэн хөтлөхийг эрхэмлэх болсноор ажиллах хүч хэмнэж, таваарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлээ нэмэгдүүлж, ашиг орлогоо арвижуулан чадаж байна. Том, жижиг ямар ч өрхийн фермерийн аж ахуй үндсэндээ бүрэн механикжиж, автоматчлагджээ. Саалийн жирийн нэг фермерийн аж ахуй гэхэд л инженерийн сүлжээгээр бүрэн тоноглогдсон, бүх үйл ажиллагаанд нь цахим тооцооны машин хяналт тавьж байна. Өвс тарих, тэжээл бэлтгэх, боловсруулах, тэжээх, услах, үнээ саах, ялгадас цэвэрлэх, зөөвөрлөх, дулааныг зохицуулах, агааржуулах зэрэг нь цөм автоматаар тохируулах төхөөрөмжтэй юм. Саалийн үнээний фермүүд дотроо ч нарийн дагнаж төрөлжсөн байна. Тухайлбал, цөцгийн тосны, эзгийний, шингэн, өтгөрүүлсэн, хуурай сүүний, цагаан идээний, холимог бүтээгдэхүүний гэх жишээтэй. Ингэж саалийн ферм дээр сүү боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулалт хийж байна. Мах, сүүний чиглэлийн фермерүүд ийнхүү мал аж ахуй, үйлдвэр, худалдааны иж бүрдэл бүхий нэгдсэн цогцолбор болон хөгжиж байна.

Америкийн хөдөө аж ахуй өндөр хөгжсөн нэг уг сурвалж нь урт хугацааны турш газрыг зүй зохистой ашиглаж хамгаалж ирсэн явдал юм. Америкт газрын тухай 2 хууль үйлчилж байна. Нэг нь бэлчээр ашиглаж мал аж ахуй эрхлэх тухай хууль нөгөө нь газрын тухай хууль юм. Бусад олон зүйлийн хууль дүрэм цөм энэ хоёр үндсэн хуулийг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

Газар ашиглах, түүнд хуулийн дагуу хяналт тавих ажлыг дотоод хэргийн департамент эрхэлнэ. Дотоод хэргийн департамент газрыг хамгаалах, ашиглахтай холбогдсон дүрэм журмыг хуулийн дагуу тогтоож, газар эзэмшигчидтэй энэ чиглэлээр хэлэлцээр байгуулж хамтран ажилладаг байна. Хөрс ургамлын бүтцийг хамгаалах, газрын үржил шимийг сайжруулахад зориулж улсаас жил бүр хэдэн зуун сая долларын хөрөнгө оруулж байна. Бэлчээр, тариалангийн талбайгаа өргөтгөх сонирхолтой фермерүүдэд тодорхой болзлын дагуу улсын өмчийн газрыг дундачаар 10 жилийн хугацаатай түрээслэж байна. Мал аж ахуй эрхэлж буй фермер улсын өмчийн газраас бэлчээрт зориулан газар түрээслэвэл уг бэлчээрт малаа зөвхөн дөрөвхөн сар бэлчээж, бэлчээрийн даацын 50 хувийг л ашиглах ёстой аж. Түүнээс хэтрүүлж ашигласан бол торгууль хүлээлгэх буюу түрээсийн гэрээгээ цуцалдаг байна. Ер нь мал аж ахуй эрхэлдэг фермерүүд өөрийн эзэмшил бэлчээрийг зөвхөн зун, намрын улиралд л ашиглаж бусад үед суурин мал-

лагааг голлож байна. Суурин маллагаа голлож байгаатай уялдан тэжээлийн үйлдвэр эрчимтэй хөгжжээ.

Америкт одоогоор тэжээлийн 10 мянга гаруй үйлдвэр байгаа бөгөөд жилдээ 7,6 сая гаруй тонн холимог, багсармал тэжээл үйлдвэрлэж байна.<sup>10</sup>

Мал аж ахуй эрхэлж буй фермерүүд тэжээл бага зарцуулдаг хээл сайн авах чадвартай, байгаль цаг уурын өөр өөр нөхцөлд нутагшин өндөр ашиг шим өгдөг малын үүлдэрийг эрхэмлэж байна. Түүнчлэн малыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэн эдгэрүүлэх ажилд улс онцгой анхаарал тавьж ихээхэн хэмжээний хөрөнгө хүч зарцуулдаг байна. Өнөөгийн байдлаар АНУ-д мал аж ахуй эрхэлж буй 19200 гаруй том, жижиг өрхийн фермерийн аж ахуй байна.<sup>11</sup> Фермерүүдийн хамгийн их анхаардаг зүйл бол өөрийн эзэмшлийн газар, түүхий эдийн агуулах, техник гурав юм. Энэ гурав сайн бол үйлдвэрлэл сайн явна гэж үздэг байна. Нөгөө нэг анхаардаг зүйл нь борлуулалт. Жишээ нь мал аж ахуй эрхэлж буй фермерүүд малын тоог тодорхой хэмжээнд барьж ашиг шимийг нэмэгдүүлж байж бүтээгдэхүүнийг аль болох хурдан борлуулахыг эрмэлздэг. Фермерийн аж ахуйн бүтэц зохион байгуулалт, технологи нь борлуулалт, зах зээлтэйгээ нягт уялдаатай байна. Улсаас фермерүүдэд тусламж дэмжлэг үзүүлдэг гол хэлбэр нь зээл юм. Фермерүүд өндөр үр ашигтай ажилладаг хэрнээ бие дааж гадаад худалдаа эрхэлдэггүй нь сонин. Энэ ажлыг улстай хоршин хийдэг ажээ.

Фермерийн аж ахуйг цогцолбор байдлаар эрчимтэй хөгжүүлж чадсанаар хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн Хэмжээгээр АНУ-д дэлхийд тэргүүлж байна. 1990 онд америкийн хөдөө аж ахуйн салбар 110 тэрбум долларын бүтээгдэхүүн үйлдвэрлэжээ.<sup>12</sup> Энэ салбарт 3 сая 100 мянга буюу хүн амын 0,9 хувь нь ажилладаг хэрнээ үндэсний орлогын 16—17 хувийг үйлдвэрлэнэ. Хөдөө аж ахуйн салбарын нэг ажиллагчийн жилийн бүтээмж нь 35,5 мянган долларт хүрч байна.<sup>13</sup> Энэ нь дэлхийд тэргүүлэх үзүүлэлт юм.

Америкийн хөдөө аж ахуйн эдэлбэр газар нийтдээ 431,5 сая га бөгөөд үүнээс хагалсан газар нь 190,0 сая га. юм. Нэг га-гаас 580 долларын бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.

Монголын тариаланчин дундачаар 11 хүн тэжээдэг байхад америкийн фермерийн эзэн 80 хүнийг хүнсээр хангадаг байна.<sup>14</sup>

НҮБ-ын мэдээгээр хүнсний бүтээгдэхүүний нэг хүнд ногдох илчлэгийн хэмжээгээр хамгийн өндөр түвшинд АНУ—3500 кКал-иор орж байна. Манай улсын нэг хүнд ногдох илчлэг 2612 кКал-байгаа нь дунд зэргийн түвшинд хамаарагдаж байна. АНУ-ын хөдөө аж ахуйн хөгжлийн дээрх үзүүлэлт цаашид ч тодорхой хугацаанд хэвээр байх төлөвтэй байгаа аж.<sup>15</sup>

АНУ үр тариаг экспортлох талаар дэлхийд томоохонд орно. Зөвхөн 1990 он гэхэд л ЗХУ (хуучин нэрээр)-д жилд дундачаар 10 сая тонн үр тариа нийлүүлж байх урт хугацааны хэлэлцээр байгуулжээ. Энэ нь олон улсын худалдааны түүхэнд хамгийн томоохонд тооцогдож байна. Олон улсын үр тарианы зөвлөлийн судалгаанаас үзэхэд 1990 оны байдлаар АНУ дэлхийн үр тарианы экспортын 34,3 хувь, малын тэжээлийн 50,5 хувийг эзэлж байв.<sup>17</sup>

АНУ-ын улс төрийн амьдралд агробизнес хүчтэй, ихээхэн үр нөлөөтэй байдаг. Тийм ч учраас хөдөө аж ахуйн салбарт улс онцгой анхаарал тавьж зарим хүндрэлтэй үед фермерийн аж ахуйнуудад тусалцаа ч үзүүлдэг. АНУ хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээр шинэ шинэ

зах зээлийг эзлэх, нөлөөний хүрээгээ өргөтгөх, ашгаа нэмэгдүүлэх сонирхолтой байдаг. Ингэхдээ фермерүүдтэй нягт хамтран ажиллаж аль аль талынхаа ашиг сонирхлыг хэрэгжүүлж чаддаг байна.

Америкийн хөдөө аж ахуйн фермерүүдийн үйл ажиллагаа бүхэлдээ асар ихээр үйлдвэрлэж, асар ихээр борлуулдаг улсын эдийн засгийнхаа бүтцийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэдэг байна.

Фермерийн аж ахуй бол АНУ төдийгүй хөгжингүй орнуудын хөдөө аж ахуйг эрхлэн хөтлөх нийтлэг хэлбэр юм.

Хөдөө аж ахуйн салбарт монгол, америкийн хамтын ажиллагааны зарим нэг эхлэл тавигдаж байна. Тухайлбал, хот сууринг сүүгээр хангах зориулалттай үхэр үржүүлдэг механикжсан фермүүдэд дэлхийд хамгийн их сүүтэй гэгдэж байгаа голштин үүлдрийн донор үнээ, буюыг цаг агаарын хувьд манайхтай ойролцоо нөхцөлтэй Америкийн Нью-Йорк мужаас авчирч цэврээр үржүүлэх, үнээнд үр хөврөл шилжүүлэн суулгаж, сүүний гарцыг нэмэгдүүлэх чиглэлээр АНУ-ын зарим пүүс, фермерийн аж ахуйтай хамтран туршилтын ажлыг эхлээд байна.

Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжиж буй энэ үед хөдөөд ардын хувийн аж ахуйтан олноор бий болж байна. Тэд бэлчээрийн мал аж ахуй эрхлэн хөтлөхдөө уламжлалаа сэргээхийг эрмэлзэж байна. Үүний хажуугаар өрнөдийн хөгжингүй орнуудын эрчимжсэн суурин мал аж ахуй эрхлэн хөтлөх нийтлэг хэлбэр болох фермерийн аж ахуйн мөн чанар үр дагавар, эерэг сөрөг тал зэргийг ултай задлан шинжлэхгүйгээр фермерийн гэсэн нэрийг нь зээлдэж, тусламжийг нь л аваад орхивол хөгжиж дэгжчих юм гэсэн өрөөсгөл ойлголт нэлээд байгаа бололтой. Бэлчээрийн мал аж ахуйг дан бусдын «туршлага», «тусламж» хоёрт дулдуйдан дорвитой хөгжүүлж болохгүй гэдгийг бид нэгэнт үзэж өнгөрүүлээ. Манай улсын хувьд хөгжингүй орнууд дахь асар асар ихээр үйлдвэрлэж, асар ихээр борлуулах системээс эрс ялгаатай, шинжлэх ухааны ололтыг уламжлалтайгаа уялдуулж, орчин нөхцөлдөө тохирсон өөрийн технологи бий болгох нь бэлчээрийн мал аж ахуйн хөгжлийн өнөөгийн тулгамдсан асуудлын нэг болж байна.

1. Paarlberg D. Farm and food policy, Lincoln, 1981, p 184
2. 1982 Census of agriculture, vol. 1, part 51, N. Y., 1984 p. 98
3. Agricultural statistics 1986, Wash., 1986, p. 370
4. «Монголын хөдөө» 1991. 3. 22
5. «Үнэн» 1991. 9. 26
6. «США; экономика, политика, идеология» М. 1989. № 12, с. 8
7. Мөн тэнд
8. Agriculture in the twenty-first century, Ed by J: Rosenblum N. Y. 1983. p 189
9. «Үнэн» 1991. 9. 26
10. «Өвөр монголын мал аж ахуй» сэтгүүл. 1991, № 8, 43-р тал
11. «Өвөр монголын мал аж ахуй» сэтгүүл. 1989, № 5, 44-р тал
12. «Ардын эрх» 1991. 7. 20
13. World agricultural statistics. 1990.  
FAO Statistical pocketbook U. N., N. Y., 1990 p. 176
14. «Ардын эрх» 1991, 8. 15
15. World economic survey 1991 current trends and policies in the world economy U. N. N. Y., 1991, p. 30
16. «США; экономика, политика, идеология» 1991, № 5, с. 77
17. International Wheat council. Market report, 10. 07, 1990